



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/797

Булган сум

Г "Үйлдвэрлэлийн сэргэлт" хөтөлбөрийг Г  
хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 2024 оны 64 дүгээр тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх "Булганы сэргэлт" үйл ажиллагааны хөтөлбөрийн 21.4.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн сэргэлт" хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн сэргэлт" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

- Ажлын хэсгийн ахлагч: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)  
Гишүүд: Г.Гантулга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Б.Ариунболд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Ч.Оюун-Эрдэнэчимэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны бодлого хариуцсан мэргэжилтэн)  
С.Алтанзул (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн)  
М.Цэрэнчимэд (Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга, хот байгуулалтын бодлого хариуцсан мэргэжилтэн, аймгийн Ерөнхий архитектор)  
Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)  
Д.Алтаншагай (Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга)

М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)  
Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга)  
Б.Батбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Жижиг,  
дунд үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн асуудал  
хариуцсан ахлах мэргэжилтэн)

Сумын Засаг дарга нар  
“Хөдөө аж ахуй-Хөгжлийн ирээдүй” ОНӨХХК  
Ажил олгогч эздийн холбоо (зөвшилцсөнөөр)  
Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын  
Булган аймаг дахь салбар (зөвшилцсөнөөр)

Тогооч нарын холбоо (зөвшилцсөнөөр)  
Хүнсчдийн холбоо (зөвшилцсөнөөр)  
Ахуйн үйлчилгээ эрхлэгчдийн холбоод  
(зөвшилцсөнөөр)

“Шидэт урлаач” ГҮТБТ (зөвшилцсөнөөр)  
Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоо  
(зөвшилцсөнөөр)

Аймгийн аялал жуулчлалын холбоо (зөвшилцсөнөөр)  
“Булган мах маркет” ХХК (Урилгаар)  
“Занадуразорбак” ХХК (Урилгаар)  
“Хатан Мээж хайрхан” ХХК (Урилгаар)  
“Дэлгэрэх фүүдс” ХХК (Урилгаар)  
“Баялаг хантай хоршоо” (Урилгаар)

Нарийн бичгийн дарга: Н.Пүрэвсайхан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

2.“Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг хангаж, судалгаа шинжилгээний болон төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран ажиллаж нэгдсэн удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлэхийг ажлын хэсэг (О.Ундрах), бүсчилсэн хөгжлийн бодлого болон төрөөс хүнс, хөдөө аж ахуй, хоршоо, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх салбарын бодлого хөтөлбөрүүдтэй уялдуулан дэмжлэг үзүүлж, ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), сумын Засаг дарга нар болон холбогдох хэлтэс агентлагийн дарга нарт, шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулж, төр, хувийн хэвшлээс хөрөнгө татаж, санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Гантулга), Санхүү төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР